

Тандалт судалгаа

КОВИД-19-ИЙН ВАКЦИНЫ ДАРААХ УРВАЛ ХҮНДРЭЛ



УДИРДАГЧ:
Д.Оюунгэрэл
ХӨСҮТ-ийн тархвар судлаач

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:
Ч.Уртнасан, ХӨСҮТ-ийн тархвар судлаач
С.Алтанчимэг, ХӨСҮТ-ийн
дархлаажуулалтын албаны мэргэжилтэн
Б.Ганцоож, ХӨСҮТ-ийн дата менежер
О.Дашпагма, ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын
албаны дарга
М.Цогт, ХӨСҮТ-ийн тархвар судлаач
А.Бурмаа, АУ-ны доктор, ХӨСҮТ-ийн тархвар
судлаач

ХӨСҮТ-ийн захиалгат ажил 2020 он.



ҮНДЭСЛЭЛ

Халдварт өвчнөөс хүн амыг хамгаалах, тархалтыг зогсоох, хүндрэл, нас баралтыг бууруулах хамгийн энгийн, найдвартай арга бол түүний эсрэг вакцинаар ард иргэд, ялангуяа эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах явдал юм. Тухайн өвчний эсрэг вакцин гарган авахад дунджаар 10-15 жил зарцуулдаг хэдий ч томуу, КОВИД-19 гэх мэт дэлхий нийтийг хамарсан цартахлын үед маш богино хугацаанд улс орны нийгэм эдийн засаг, эрүүл мэндийн салбар дарамтанд орж, хүний эрүүл мэнд хохирч байдаг учраас олон жилийн судалгаа шинжилгээ хийлгүүгээр, богино хугацаанд вакциныг гарган авч хүн амыг дархлаажуулж хамгаалах нь чухал байдаг.

КОВИД-19-ийн вакцин шинэ, богино хугацаанд гарган авсан вакцинаар хүн амыг дархлаажуулсны дараа судалгаа, шинжилгээгээр илрүүлээгүй, ховор, маш ховор урвал, хүндрэлийг илрүүлж хянах нь цаашдын дархлаажуулалтын аюулгүй байдалд өндөр ач холбогдолтой байдаг.

Монгол улс 2021 оны 2 сарын 23-ны өдрөөс эхлэн КОВИД-19-ийн эсрэг вакцинаар хүн амаа дархлаажуулж эхэлсэн. 2021 оны 8 сарын 30-ны байдлаар 4 төрлийн вакцинаар зорилтот бүлгийн хүн амын 94.8%-ийг эхний тунгаар, 88.3%-ийг хоёр дахь тунгаар дархлаажуулаад байна.

ЗОРИЛГО

Монгол улсын хүн амын дунд КОВИД-19-ийн эсрэг дархлаажуулалтын дараа илэрсэн урвал хүндрэлийг вакцин тус бүрээр тандан судалж, бусад улс орнуудтай харьцуулан судлах.

АРГА ЗҮЙ


Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл (ДДУХ) гэдэг нь вакцин хийлгэсний дараа хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой эсвэл ноцтой хямралыг хэлнэ.

Судалгааны хүн амыг вакцин тариулсан иргэдээс санамсаргүй байдлаар түүвэрлэн авсан. Вакцинд хамрагдсан хүмүүсийн холбогдох мэдээллийг урьдчилан “Дархлаажуулалтын цахим сан”-гаас авч бэлтгэсэн ба бэлтгэгдсэн судлаач нар утсаар вакцинжуулалтын дараа илэрсэн түгээмэл илрэх урвалыг тусгай боловсруулсан асуумжийн дагуу асууж мэдээллийг цуглуулсан.

ҮР ДҮН

Манай улсад КОВИД-19-ийн дархлаажуулалт 2021 оны 2 сарын 23-ны өдөр эхэлсэн. 2021 оны 6 сарын 1-ний байдлаар 1-р тунд 1,859,509, 2-р тунд 1,306,462 хүн хамрагдсан байна. Бид судалгаандаа дөрвөн вакцин тус бүрээр 1,000 хүнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон авч хамруулсан ба Вероцелл вакцин хийлгэсэн 2 хүн, Гам-КОВИД-Вак вакцин хийлгэсэн 4 хүний мэдээлэл дутуу байсан учраас судалгааны хүн амаас хасаж тооцооллыг хийсэн.

Вакцинжуулалтад хамрагдсан хүн амыг насны бүлгээр харьцуулан үзвэл 30-39 насны хүмүүс хамгийн өндөр буюу 947 (23.7%), 80 болон түүнээс дээш насны хүмүүс хамгийн бага буюу 69 (1.7%) байна. 20-39 насанд эрэгтэйчүүд, бусад насны бүлэгт эмэгтэйчүүд 50-аас дээш хувийг эзэлж байна (Зураг 1).



Зураг 1. Судалгааны хүн ам насны бүлэг, хүйсээр

Вакцинжуулалтын дараа түгээмэл илрэх хөнгөн урвал 1-р тунгийн дараа



2,253 (56.4%) хүнд, 2-р тунгийн дараа 345 (8.6%) хүнд илэрсэн байна. 1-р тунгийн дараа АстраЗенека-Ковишилд вакцинд хамрагдсан хүмүүсийн 79%-д нь түгээмэл илрэх хөнгөн урвал илэрсэн нь бусад 3 вакцинтай харьцуулахад хамгийн өндөр байсан бол Вероцелл вакцинд хамрагдсан хүмүүст хамгийн бага (33.3%) хувьтай илэрсэн байна. 2-р тунгийн дараа Вероцелл вакцин хийлгэсэн хүмүүсийн дунд (17.2%) түгээмэл илрэх хөнгөн урвал бусад вакцинтай харьцуулахад харьцангуй өндөр байсан бол Гам-КОВИД-Вак вакцин хийлгэсэн хүмүүст урвал илрээгүй байна (Хүснэгт 1).

Дархлаажуулалтын дараа илэрсэн урвалын тоо, вакцин тус бүрээр

Хүснэгт 1.

ДДУХ / АЕФИ	I тун	II Тун
Вероцелл	332 (33.3%)	165 (17.2%)
АстраЗенека-Ковишилд	790 (79.0%)	47 (4.8%)
Комирнэти	636 (63.6%)	133 (13.6%)
Гам-КОВИД-Вак	495 (49.7%)	0 (0.0%)
Нийт	2,253 (56.4%)	345 (8.6%)

Вакцинжуулалтын дараа илэрсэн урвалын улмаас 1-р тунгийн дараа 72 (7.6%), 2-р тунгийн дараа 506 (16.6%) хүн эрүүл мэндийн байгууллагад хандсан байна. Вакцины 1-р тунгийн дараа урвал вакцин

тариулснаас хойш дунджаар 1.5 хоног (хамгийн бага 24 цагийн дотор, хамгийн их 28 хоног)-ийн дараа илэрсэн бол 2-р тунгийн дараа урвал 289 (83.3%) хүнд 24 цагийн дотор, 31 (8.9%)-д нь 1 хоногийн дараа илэрсэн байна.

Вакцины 1-р тунгийн дараа нийт 37 түгээмэл илрэх хөнгөн болон хүнд урвалын шинж тэмдэг илэрснээс тариулсан газар хөндүүрлэх (26.9%), толгой өвдөх (19.9%), 390С-ээс доош халуурах (14.9%), бие зарайх (12.5%), үе мөчөөр өвдөх (10.4%), ядрах (10.0%), нойр ихээр хүрэх (6.2%), булчин өвдөх (26.9%), дотор муухайрах (3.6%), даралт ихсэх (3.6%) шинж тэмдэг нийтлэг илэрсэн байна. Вакцин тус бүрээр харьцуулан 1-р тунгийн дараа илэрсэн урвалыг харуулав. (Хүснэгт 2.)

Вакцины 2-р тунгийн дараа илэрсэн түгээмэл илрэх хөнгөн урвалын тоо эхний тунтай харьцуулахад 47.8%-иар буурсан байна. Тариулсан газар хөндүүрлэх (18.4%), толгой өвдөх (11.5%), 390С-ээс доош халуурах (5.1%), бие зарайх (5.0%), үе мөчөөр өвдөх (4.7%), ядрах (5.9%), нойр ихээр хүрэх (3.7%), булчин өвдөх (2.1%), дотор муухайрах (1.7%), даралт ихсэх (2.9%) шинж тэмдэг нийтлэг илэрсэн байна.

Вакцин тус бүрээр харьцуулан 2-р тунгийн дараа илэрсэн урвалыг харуулав. (Хүснэгт 3.)

КОВИД-19 вакцины 1-р тунгийн дараа илэрсэн урвал вакцин тус бүрээр Хүснэгт 2.

№	Урвал Adverse event after immunization	Нэгдүгээр тун /1st dose/				
		Нийт Total (n=3,994)	Вероцелл Vero cell (n=998)	АстраЗенека- Ковишилд AstraZeneca- Covishield (n=1,000)	Комирнэти Comirnaty (n=1,000)	Гам-КОВИД- Вак Gam- COVID-Vac (n=996)
1	Тариулсан газарт хөндүүлэх	26.9%	6.9%	33.3%	48.9%	18.6%
2	Толгой өвдөх	19.9%	12.9%	32.8%	17.1%	16.9%
3	Халуурах 39 доош	14.9%	2.6%	41.0%	5.1%	10.8%
4	Бие зарайх	12.5%	4.6%	25.2%	9.6%	10.7%
5	Үе мөч өвдөх	10.4%	4.5%	23.7%	5.5%	7.7%
6	Ядрах	10.0%	4.6%	18.0%	9.2%	8.3%
7	Нойр ихээр хүрэх	6.2%	7.8%	7.0%	4.3%	5.7%
8	Булчин өвдөх	5.9%	1.9%	15.2%	2.4%	3.9%
9	Бусад	5.2%	4.5%	7.6%	6.1%	2.6%
10	Дотор муухайрах	3.6%	2.5%	7.1%	2.6%	2.0%
11	Даралт ихсэх	3.6%	4.3%	3.3%	3.4%	3.2%
12	Хөлрөх	3.3%	2.1%	0.0%	0.0%	2.3%
13	Толгой эргэх	2.6%	2.7%	4.1%	1.8%	1.8%
14	Гар хөл бабайрах	2.0%	2.0%	3.5%	1.1%	1.2%
15	Тариулсан газарт хавдах	1.6%	0.3%	2.1%	1.8%	2.3%
16	Тариулсан газарт улайх	1.0%	0.4%	1.9%	0.6%	1.2%
17	Хоолой хөндүүлэх	1.0%	0.9%	0.9%	1.0%	1.3%
18	Тайван бус болох	1.0%	0.0%	2.1%	1.0%	0.7%
19	Хоолонд дургүй болох	0.9%	0.0%	2.0%	0.8%	0.5%
20	Нус гоожих	0.9%	0.5%	1.1%	0.9%	0.9%
21	Чичрэх	0.8%	0.5%	1.9%	0.2%	0.4%
22	Нойргүйдэх	0.7%	0.5%	1.7%	0.3%	0.4%
23	Хамар битүүрэх	0.6%	0.5%	0.6%	0.2%	0.9%
24	Суулгах	0.4%	0.6%	0.6%	0.1%	0.3%
25	Туурах	0.4%	0.3%	0.3%	0.3%	0.6%
26	Тарьсан газар загатнах	0.4%	0.1%	0.2%	0.4%	0.4%
27	Бөөлжих	0.3%	0.0%	0.8%	0.2%	0.0%
28	Ханиах	0.3%	0.2%	0.3%	0.3%	0.3%
29	Гэдэс өвдөх	0.3%	0.2%	0.5%	0.2%	0.1%
30	Амлах мэдрэхүй алдагдах	0.1%	0.0%	0.3%	0.0%	0.1%
31	Тарьсан газар хөхрөх	0.1%	0.1%	6.8%	1.9%	0.3%
32	Үнэрлэх мэдрэхүй алдагдах	0.1%	0.3%	0.2%	0.0%	0.1%
33	Лимфаденит (1.5см бага)	0.3%	0.0%	0.5%	0.4%	0.0%
34	Халуурах 39 дээш	0.9%	0.2%	3.1%	0.1%	0.3%
35	Амьсгал бачуурах	0.2%	0.0%	0.0%	0.3%	0.1%
36	Арьсны харшлын урвал	0.1%	0.0%	0.1%	0.0%	0.2%
37	Нүүрний болон бүх биеийн хаван	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%
38	Ухаан балартаж унах	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%

КОВИД-19 вакцины 2-р тунгийн дараа илэрсэн урвал вакцин тус бүрээр Хүснэгт 3.

№	Урвал Adverse event after immunization	Хоёрдугаар тун /2nd dose/				
		Нийт Total (n=3,005)	Вероцелл Vero cell (n=998)	АстраЗенека- Ковишилд AstraZeneca- Covishield (n=1,000)	Комирнэти Comirnaty (n=1,000)	Гам-КОВИД- Вак COVID-Vac (n=996)
1	Тариулсан газарт хөндүүрлэх	18.4%	7.0%	10.9%	37.2%	18.3%
2	Толгой өвдөх	11.5%	10.7%	9.5%	14.4%	10.7%
3	Халуурах 39 доош	5.1%	1.5%	5.6%	8.5%	3.8%
4	Жихүүдэс хүрэх	5.0%	2.3%	4.4%	8.1%	6.1%
5	Үе мөч өвдөх	4.7%	3.9%	4.1%	6.2%	4.6%
6	Ядрах	5.9%	4.0%	3.8%	9.9%	5.3%
7	Нойр ихээр хүрэх	3.7%	6.4%	1.9%	3.3%	1.5%
8	Булчин өвдөх	2.1%	1.8%	2.0%	2.4%	3.8%
9	Бусад	4.7%	4.8%	3.2%	6.7%	0.8%
10	Дотор муухайрах	1.7%	1.6%	1.3%	2.4%	0.8%
11	Даралт ихсэх	2.9%	3.1%	2.2%	3.6%	0.0%
12	Хөлрөх	1.3%	1.7%	0.4%	0.0%	2.3%
13	Толгой эргэх	1.5%	2.0%	1.2%	1.6%	0.0%
14	Гар хөл бабайрах	1.6%	2.5%	1.6%	1.0%	0.0%
15	Тариулсан газарт хавдах	0.9%	0.3%	0.4%	1.7%	2.3%
16	Тариулсан газарт улайх	0.3%	0.2%	0.4%	0.3%	0.0%
17	Хоолой хөндүүрлэх	0.8%	0.9%	0.5%	0.8%	1.5%
18	Тайван бус болох	0.4%	0.1%	0.0%	1.0%	0.0%
19	Хоолонд дургүй болох	0.4%	0.2%	0.1%	1.0%	0.0%
20	Нус гоожих	0.4%	0.3%	0.5%	0.3%	0.0%
21	Чичрэх	0.5%	0.0%	0.3%	1.1%	0.8%
22	Нойргүйдэх	0.3%	0.2%	0.5%	0.4%	0.0%
23	Хамар битүүрэх	0.4%	0.5%	0.2%	0.3%	0.0%
24	Суулгах	0.2%	0.5%	0.1%	0.0%	0.0%
25	Туурах	0.5%	0.5%	0.2%	0.8%	0.0%
26	Тарьсан газар загатнах	0.3%	0.2%	0.6%	0.4%	0.8%
27	Бөөлжих	0.1%	0.0%	0.2%	0.2%	0.0%
28	Ханиах	0.4%	1.0%	0.1%	0.2%	0.0%
29	Гэдэс өвдөх	0.2%	0.2%	0.1%	0.4%	0.0%
30	Амлах мэдрэхүй алдагдах	0.1%	0.3%	0.1%	0.0%	0.0%
31	Тарьсан газар хөхрөх	0.1%	0.1%	0.1%	1.6%	0.8%
32	Үнэрлэх мэдрэхүй алдагдах	0.2%	0.0%	0.1%	0.1%	0.0%
33	Лимфаденит (1.5см бага)	0.2%	0.1%	0.0%	0.4%	0.0%
34	Халуурах 39 дээш	0.4%	0.3%	0.1%	0.9%	0.0%
35	Амьсгал бачуурах	0.2%	0.4%	0.1%	0.1%	0.0%
36	Арьсны харшлын урвал	0.1%	0.1%	0.0%	0.0%	0.0%
37	Нүүрний болон бүх биеийн хаван	0.0%	0.1%	0.0%	0.0%	0.0%
38	Ухаан багартаж унах	0.1%	0.2%	0.1%	0.0%	0.0%

Бусад урвал 274 (6.9%) хүнд илэрсэн ба үүнээс Вероцелл хийлгэсэн 64 (6.4%), АстраЗенека-Ковишилд хийлгэсэн 95 (9.5%), Комирнэти хийлгэсэн 83 (8.3%), Гам-КОВИД-Вак хийлгэсэн 32 (3.2%) хүнд тус тус илэрсэн байна. Зүрх дэлсэх (1.1%), нуруу өвдөх (0.4%), толгой манарах (0.3%), бөөр өвдөх (0.3%) шинж давамгай илэрсэн байна. Вакцинжуулалтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дунд сарын тэмдгийн мөчлөг өөрчлөгдсөн гэж 32 (1.4%) эмэгтэй хариулсан ба АстраЗенека-Ковишилд вакцин хийлгэсэн эмэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр (2.9%), Гам-КОВИД-Вак хийлгэсэн эмэгтэйчүүдэд хамгийн бага (0.5%) илэрсэн байна.

ДҮГНЭЛТ:

Манай судалгаанд АстраЗенека-Ковишилд, Вероцелл, Комирнэти, Гам-КОВИД-Вак вакцинаар вакцинжуулагдсан иргэдийн дунд илрэх ДДУХ вакциныг ханган нийлүүлж буй үйлдвэрлэгч байгууллагаас вакцитай хамт дагалдан ирдэг зааварт тусгасан ДДУХ-тэй харьцуулахад давтамжийн хувь бага байна. Нойр ихээр хүрэх, даралт ихсэх, толгой эргэх, гар хөл бадайрах шинж манай судалгаанд оролцогчдод илэрсэн байгаа нь бусад улсын судалгаануудтай харьцуулахад онцлог байв.

